



**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД
БОДЛОГЫН ИННОВАЦИЙГ ТУРШИН НЭВТРҮҮЛЭХ БИЧИЛ ТӨСӨЛ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ
(Сонгон шалгаруулалтад оролцогчдод зориулав)**

Дэлхийн олон улс оронд төрийн үйлчилгээг оновчтой хүргэх, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар төрийн үйлчилгээг зохион байгуулах, тулгамдаж буй асуудалд уламжлалт бус арга, шинэлэг хэлбэрээр хариу арга хэмжээ авах замаар эерэг үр дүнд хүрч буй жишээ олон байна.

Иймд төрийн байгууллагууд хариуцсан чиг үүрэг, стратеги зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд бодлогын тодорхой асуудлаар шинэлэг шийдэл боловсруулах төслийн саналаа Төрийн албаны зөвлөлийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн нэгжид 2020 оны 5 дугаар сарын 11-ний дотор ирүүлнэ. Ирүүлсэн саналуудаас нийт 9 саналыг сонгон шалгаруулж, цаашид хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Шинэлэг шийдэл туршихад хэрэглэж болох аргууд:

- Системийн сэтгэлгээ (Systems Thinking)
- Загварчлалын сэтгэлгээ (Design Thinking)
- Зан үйлд нөлөөлөх чадвар (Behavioral Insights)

Эдгээр аргуудын талаарх нэмэлт мэдээлэл, жишээг Төрийн албаны зөвлөлийн <http://www.csc.gov.mn> цахим хуудсанд байршуулсан.

Туршилтын төслийн үргэлжлэх хугацаа

Энэхүү туршилтын төсөл нь нийт 4 сарын хугацаанд 4 үе шаттай явагдана. Үүнд:

1 дүгээр үе шат. Төрийн байгууллагуудаас төслийн санал хүлээн авах.	2020 оны 5 сарын 11 хүртэл
2 дугаар үе шат. Хүлээн авсан төслийн саналуудаас сонгон шалгаруулах	2020 оны 5 сарын 15
3 дугаар үе шат. Туршилтын төслөө хэрэгжүүлэх, баримтжуулах, тайлангаа бэлтгэх.	2020 оны 5 сарын 18-наас 8 сарын 27 хүртэл

4 дүгээр үе шат. Туршилтын төслийн хаалтын семинарт үр дүнгээ танилцуулах	2020 оны 9 сарын 5
---	--------------------

Төслийн санал ирүүлэх

Төслийн санал боловсруулахдаа хавсралт Төслийн санал ирүүлэх маягтыг ашиглах бөгөөд policyinnovationmn@gmail.com хаягаар илгээнэ.

Хавсралт. Төслийн санал ирүүлэх маягт

Төслийн нэр:	
Байгууллага, газар, хэлтэс:	
Төслийг хариуцаж ажиллах баг: Багийн ахлагч, гишүүд (3-5)	
Шийдэх гэж буй асуудал (бодлогын том асуудал биш, богино хугацаанд туршиж, үр дүнг нь харж болохуйц практик асуудал байх)	
Зорилтот бүлэг	
Байгууллагын чиг үүрэг, стратеги зорилготой уялдсан байдал	
Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал/Тогтвортой хөгжлийн аль зорилгод хамаарах	
Тухайн асуудлыг өмнө нь ямар аргаар шийдвэрлэж ирсэн, ямар үр дүнтэй байгаа талаар хийсэн товч дүн шинжилгээ	
Санал болгож буй арга зүйгээс алийг нь ашиглах	
Хэрэгжүүлэх хугацаа	

---oOo---